



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 13 өдөр

Дугаар A/09

Номгон

Сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын  
багийн бүрэлдэхүүнийг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хохирогч хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл санааг хэвийн болгоход дэмжлэг үзүүлэх олон талт арга хэмжээ зохион байгуулах үүрэг бүхий сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багийг 5-9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хавсралтаар баталсугай.

2. Гэр бүлийн болон бусад орчинд үйлдэгдсэн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлсэн тайланг хагас, бүтэн жилээр сумын Засаг даргын зөвлөлд тайлагнаж ажиллахыг Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багийн ахлагч (захирал, эрхлэгч) нарт үүрэг болгосугай.

3. Хүүхэд хамгааллын багуудыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн асуудал хариуцсан мэргэжилтэн (О.Дашдаваа)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Орлогч (С.Батцэрэн)-д даалгасугай.

ДАРГА  
Г.ЭНХБАЯР

Захирамж 2022 он

6.10.10809



17

Баянхонгор сумын Засаг даргын ..... оны  
...01... дүгээр сарын 12 -ны өдрийн A/09  
дүгээр захирамжийн хавсралт

СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН  
БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Сургууль:

Хүүхэд хамгааллын багийн ахлагч:	Сургуулийн захирал
Гишүүн	Сургалтын менежер
	Сургуулийн эмч
	Багш
Нарийн бичгийн дарга	Сургуулийн Нийгмийн ажилтан

Цэцэрлэг:

Хүүхэд хамгааллын багийн ахлагч:	Цэцэрлэгийн эрхлэгч
Гишүүн	Эмч
	Бүлгийн багш
	Бүлгийн багш
Нарийн бичгийн дарга:	Арга зүйч

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_